

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2026/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр Утас: 7037-3089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Дархан-Уул аймаг 2026 он	Аудитын менежер У.Батсүрэн Утас: 7037-3089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn
	Ахлах аудитор С.Батцэцэг Утас: 7037-3089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.20 № 213
танай _____-ны № _____-т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.АЗЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн төсвийн орлого 26,139.3 сая төгрөгөөр буюу 21.1 хувиар давж биелсэн тул Монгол Улсын Сангийн яам болон Дархан-Уул аймгийн ЗДТГ хооронд байгуулсан Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжсэн "Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл"-ийн зээлийн өр төлбөрийг бүрэн барагдуулах нөхцөл бүрдэж, тус зээлийн өр төлбөр, зээлийн хүүд нийт 38,346.0 сая төгрөг төлж, үлдэгдэлгүй болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт үйл ажиллагааны зардал 111,433.6 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 29,145.4 сая төгрөгөөр өссөн нь 2200 хүний суудалтай спорт цогцолборын "Дархан юнайтед арена" ОНӨААТҮГ

4529050346

шинээр байгуулагдсан, төсвийн урсгал зардал, улсад төвлөрүүлэх дүн болон дамжуулан зээлийн хүүгийн зардал нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Бусад асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 151 арга хэмжээний хэрэгжилтийг Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс 91.61 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		57,529,014.6	46,937,046.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	49,307,157.0	32,991,872.7
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	2,703,789.9	3,194,629.8
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	446,865.7	374,522.3
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	4,630,666.6	5,768,718.5
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	169,070.6	263,874.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	271,464.7	4,343,428.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		283,123,845.5	284,312,424.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	283,123,845.5	284,312,424.5
39200	Биет хөрөнгө		230,027,484.9	231,312,075.1
39300	Биет бус хөрөнгө	13	53,094,760.6	52,997,949.4
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	1,600.0	2,400.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		340,652,860.1	331,249,470.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		64,780,365.4	15,099,473.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		53,076,667.6	14,736,059.9
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	31,086,579.5	-
41300	Өглөг		21,978,751.8	14,656,420.4
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	11,336.4	79,639.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		11,703,697.8	363,413.3
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	11,703,697.8	363,413.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		275,872,494.7	316,149,997.5
51	Засгийн газрын хувь оролцоо		275,872,494.7	316,149,997.5
51100	Засгийн газрын оруулсан капитал		18,931,779.7	18,745,555.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		5,242,763.9	5,224,570.4
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		219,215,749.9	231,111,609.5
51200	Хуримтлагдсан үр дүн		(1,570,559.7)	27,362,066.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		34,052,760.9	33,706,195.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		340,652,860.1	331,249,470.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		155,610,110.4	170,222,231.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		73,583,368.9	95,681,114.0
110	Орлогын албан татвар		62,466,873.6	77,514,315.0
1100	Хувь хүний орлогын албан татвар		57,483,625.5	64,982,566.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(3,345,948.9)	(3,982,213.1)
1103	ААН-ын орлогын албан татвар		8,329,197.0	16,513,961.6
113	Хөрөнгийн албан татвар		4,060,346.7	4,346,420.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж		7,056,148.6	13,820,378.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	73,983,848.4	74,541,117.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		8,042,893.2	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	82,288,225.2	111,437,520.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		82,288,225.2	111,415,487.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		72,615,085.2	87,936,838.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		25,077,999.1	30,623,665.1
2102	Ажил олгогчоос төлөх НДШ		3,172,995.0	4,080,131.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		7,687,496.6	9,699,970.4
2104	Хангамж, бараа материалын зардал		2,003,055.1	2,191,643.0
2105	Нормативт зардал		694,525.3	500,534.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,657,254.8	3,240,560.8
2107	Томилолт, зочны зардал		236,687.8	162,644.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,009,191.5	10,605,369.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		25,075,880.0	26,832,319.0
211	ХҮҮ		-	7,259,394.8
212	ТАТААС		3,120,388.8	3,509,401.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,552,751.2	12,709,853.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	22,032.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		73,321,885.2	58,784,711.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	108,962.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		28,084,346.7	30,521,566.4
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(28,084,346.7)	(30,412,604.2)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		45,237,538.5	28,372,106.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	141,397,809.6	179,158,747.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	72,084,649.7	93,753,034.7
110	Орлогын албан татвар	62,466,873.6	77,514,315.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(3,345,948.9)	(3,982,213.1)
1103	ААН-ын орлогын албан татвар	8,329,197.0	16,513,961.6
113	Хөрөнгийн албан татвар	4,060,346.7	4,346,420.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,557,429.5	11,892,299.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	906,003.8	8,236,350.0
1181	Газрын төлбөр	3,186,791.5	3,143,332.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,464,634.2	512,616.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,403,201.4	85,405,713.2
120	Нийтлэг татварын бус орлого	42,379,540.6	71,018,842.9
122	Тусламжийн орлого	-	1,252,605.3
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	20,023,660.8	13,134,265.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,909,958.5	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	117,659,720.1	151,110,972.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	117,659,720.1	151,110,972.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	86,513,460.5	97,055,397.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,619,072.8	34,254,349.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,353,563.9	3,477,467.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,104,903.4	9,972,629.9
2104	Хангамж, бараа материалын зардал	8,046,591.3	8,938,623.8
2105	Нормативт зардал	458,085.0	507,956.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,505,750.3	1,963,941.9
2107	Томилолт, зочны зардал	206,141.6	144,648.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,752,752.0	12,315,188.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,466,600.3	25,480,590.6
211	ХҮҮ	21,850,000.0	38,345,974.3
212	ТАТААС	2,856,844.8	3,510,341.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,439,414.8	12,199,259.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	23,738,089.5	28,047,775.7
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	10,170.3	13,490.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	29,431,387.5	44,027,381.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,431,387.5	44,027,381.3
2200	Дотоод эх үүсвэрээр	26,918,310.3	42,219,838.6
2260	Гадаад эх үүсвэрээр	2,513,077.1	1,807,542.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(29,421,217.2)	(44,013,890.7)
14	Бусад эх үүсвэр	630,000.0	608,962.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	58,000.0	373,283.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	778,899.4	584,848.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(206,899.4)	(349,169.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(5,890,027.0)	(16,315,284.3)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,197,184.0	49,307,157.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,307,157.0	32,991,872.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	202,145,737.8	-	202,145,737.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	68,616.5	-	68,616.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	202,214,354.3	-	202,214,354.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	13,422,943.9	-	13,422,943.9
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	15,091,714.8	-	15,091,714.8
8	Зарласан ногдол ашиг	(94,084.0)	-	(94,084.0)
9	Тайлант үеийн үр дүн	45,225,449.0	-	45,225,449.0
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,860,378.0	-	275,860,378.0
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	275,860,378.0	-	275,860,378.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	637,573.4	-	637,573.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	276,497,951.4	-	276,497,951.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,249,019.1	-	1,249,019.1
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	7,173,296.8	-	7,173,296.8
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	2,922,588.4	-	2,922,588.4
18	Зарласан ногдол ашиг	(64,965.1)	-	(64,965.1)
19	Тайлант үеийн үр дүн	28,372,106.9	-	28,372,106.9
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,149,997.5	-	316,149,997.5

Гурав. Аудитын илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар нийт 36,739.1 сая төгрөгийн 7 алдаа¹ илэрснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т *"Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна"* гэж заасны дагуу зохих дансанд бүртгүүлж, аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Дархан-Уул аймгийн ЗДТГ нь хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилгын 298.1 сая төгрөгийн зураг төсвийн үнийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн нь УСНББОУС1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан *"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"*-ын 5.4.4-т заасантай тус тус нийцэхгүй, "Толилуулга", "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайланд "Дуусаагүй үйлдвэрлэл" дансыг бууруулж, "Бусад эргэлтийн хөрөнгө" дансыг нэмэгдүүлж,
2. "Дархан орон нутгийн зам тээвэр" ОНӨААТҮГ элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг 7.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоож, хүлээн зөвшөөрөхдөө хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд бичсэн нь УСНББОУС1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-тай тус тус нийцэхгүй, "Толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайланд "Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү" дансыг бууруулж, санхүүгийн үр дүнгийн тайланд "Бусад орлого" дансыг нэмэгдүүлж,
3. "Дархан юнайтед арена" ОНӨААТҮГ-ын үр дүнгийн тайланд 853.3 сая төгрөгийн борлуулалтын орлогыг ангилал зөрүүлэн бүртгэсэн нь УСНББОУС1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын 5 дугаар хавсралт "Орлогын эдийн засгийн ангиллын тайлбар"-тай тус тус нийцэхгүй, "Толилуулга", "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайланд "Үндсэн үйл ажиллагааны орлого" дансыг бууруулж, "Борлуулалтын орлого /ТӨҮГ/" дансыг нэмэгдүүлж,
4. "Дархан юнайтед арена" ОНӨААТҮГ-ын мөнгөн гүйлгээний тайланд 1,025.0 сая төгрөгийн борлуулалтын орлогыг ангилал зөрүүлэн бүртгэсэн нь УСНББОУС1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын 5 дугаар хавсралт "Орлогын эдийн засгийн ангиллын тайлбар"-тай тус тус нийцэхгүй, "Толилуулга", "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мөнгөн гүйлгээний тайланд "Үндсэн үйл ажиллагааны орлого" дансыг бууруулж, "Борлуулалтын орлого /ТӨҮГ/" дансыг нэмэгдүүлж,
5. "Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ-ын санхүүгийн байдлын тайланд 34,286.2 сая төгрөгийн эздийн өмчийн дүнг ангилал зөрүүлэн бүртгэсэн нь УСНББОУС1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-тай тус тус нийцэхгүй, "Толилуулга", "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайланд "Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө" дансыг бууруулж, "Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/" дансыг нэмэгдүүлж,
6. "Дархан дахин төлөвлөлт" ОНӨААТҮГ-ын үр дүнгийн тайланд 268.7 сая төгрөгийн татаас санхүүжилтийн орлогыг борлуулалтын орлогоор бүртгэсэн нь УСНББОУС1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын 5 дугаар хавсралт "Орлогын эдийн засгийн ангиллын тайлбар"-тай тус тус нийцэхгүй, "Толилуулга", "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

санхүүгийн үр дүнгийн тайланд “Борлуулалтын орлого /ТӨҮГ/” дансыг бууруулж, “Бусад орлого” дансыг нэмэгдүүлж,

7. "Дархан үйлдвэрлэл технологийн парк" ОНӨААТҮГ нь 0.3 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлыг ангилал зөрүүлэн бүртгэсэн нь УСНББОУС1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, УСНББОУС35 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан”, Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан "ТЕЗ-ийн болон ЗГСНТ, тодруулга бэлтгэх журам"-ын 4.2.1-д заасантай тус тус нийцэхгүй, “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг бууруулж, ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/ дансыг нэмэгдүүлж, тус тус залруулав.

3.1.1.Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

3.1.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

3.1.3 Зөвлөмж

Аудитаар орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт:

“Дархан үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ, “Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ-ууд нь тайлант онд дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй нь аймгийн ИТХТ-ийн 2020 оны 96 дугаар тогтоолын хавсралтаар баталсан дүрмийн 1.4, 4,3, 2021 оны 90 дүгээр тогтоолоор баталсан дүрмийн 1.5, 3.1 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй орон нутгийн өмчит газруудын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж, дүн шинжилгээ хийн, үр дүнг шийдвэрлэх.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн нэгтгэл

№	Төсөв захирагчийн ангилал	Нэгтгэсэн байгууллагын тоо	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийх	Аудитад хамрагдаагүй	Гаргасан дүгнэлт			
					Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Татгалзсан
1	ТЕЗ	1	-	-	1	-	-	-
2	ТТЗ	4	-	-	4	-	-	-
3	ТШЗ	20	2	-	13	5	-	-
4	ОНТС	10	6	-	3	1	-	-
5	Төсөл сан	1	-	-	1	-	-	-
6	ОНӨААН	22	1	-	18	3	-	-
	Бүгд дүн	58	9	-	40	9	-	-

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

№	Байгууллагын нэр		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
									Тоо	Дүн	Тоо	Дүн		
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	ТШЗ	Дархан-Уул аймгийн ЗДТГ	3	20,077,999.9	-	-	3	20,077,999.9	3	20,077,999.9	-	-	-	-
2		Хонгор сумын ЗДТГ	2	71,289.0	-	-	2	71,289.0	2	71,289.0	-	-	-	-
3		Хонгор сумын ОНХС	1	3,712,804.5	1	3,712,804.5	-	-	1	3,712,804.5	-	-	-	-
4		Дархан сумын ОНХС	1	254,828.5	-	-	1	254,828.5	1	254,828.5	-	-	-	-
5		Орхон сумын ОНХС	2	316,736.0	-	-	2	316,736.0	2	316,736.0	-	-	-	-
6		Хонгор сумын ХХС	1	135,766.0	-	-	1	135,766.0	1	135,766.0	-	-	-	-
7		Шарын гол сумын ЗДТГ	1	122,882.2	-	-	1	122,882.2	1	122,882.2	-	-	-	-
			Дүн	11	24,692,306.1	1	3,712,804.5	10	20,979,501.6	11	24,692,306.1	-	-	-
1	ТТЗ	Орхон сумын ТТЗ	2	176,908.3	1	134,612.1	1	42,296.2	2	176,908.3	-	-	-	-
2		Дархан сумын ТТЗ	1	64,250.1	-	-	1	64,250.1	1	64,250.1	-	-	-	-
3		Шарын гол сумын ТТЗ	2	560,509.8	-	-	2	560,509.8	2	560,509.8	-	-	-	-
			Дүн	5	801,668.2	1	134,612.1	4	667,056.1	5	801,668.2	-	-	-
1	ОНӨААН	Эрчим хүчний зохицуулах зөвлөл	3	2,547.5	1	976.9	2	1,570.6	3	2,547.5	-	-	-	-
2		Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ	1	3,400.0	-	-	1	3,400.0	1	3,400.0	-	-	-	-
3		Орхон Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	5	46,619.1	3	10,656.3	2	35,962.8	5	46,619.1	-	-	-	-
4		ДОНЗТ ОНӨААТҮГ	1	13,775.1	-	-	1	13,775.1	1	13,775.1	-	-	-	-
5		ДХББЗГ ОНӨААТҮГ	3	41,219.9	-	-	3	41,219.9	3	41,219.9	-	-	-	-
6		ДХТҮГ ОНӨААТҮГ	4	828,899.0	-	-	4	828,899.0	4	828,899.0	-	-	-	-
7		Дархан хотын хог тээвэр ОНӨААТҮГ	4	657,665.0	-	-	4	657,665.0	4	657,665.0	-	-	-	-
8		Хонгор хот тохижилт ОНӨААТҮГ	1	174,074.4	-	-	1	174,074.4	1	174,074.4	-	-	-	-
9		Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ	1	6,120.0	-	-	1	6,120.0	1	6,120.0	-	-	-	-
10		ХААТҮДТ ОНӨААТҮГ	1	56,920.6	-	-	1	56,920.6	1	56,920.6	-	-	-	-
11		Тулга сувилал ОНӨААТҮГ	1	17,253.6	-	-	1	17,253.6	1	17,253.6	-	-	-	-
12		Дархан юнайтед арена ОНӨААТҮГ	3	261,676.3	-	-	3	261,676.3	3	261,676.3	-	-	-	-
		Дүн	28	2,110,170.5	4	11,633.2	24	2,098,537.3	28	2,110,170.5	-	-	-	-
1	ТЕЗ	Аймгийн нэгтгэсэн тайлан	7	36,739,075.5	-	-	7	36,739,075.5	7	36,739,075.5	-	-	-	-
		Бүгд дүн	51	64,343,220.3	6	3,859,049.8	45	60,484,170.5	51	64,343,220.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

№	Байгууллагын нэр		Нийт зөрчил		Үүнээс									
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан тушаалтан		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	ТШЗ	Дархан сумын ИТХ	2	435,862.8	-	-	1	435,000.0	1	862.8	-	-	-	-
2		Дархан сумын ЗДТГ	2	3,993.7	-	-	-	-	2	3,993.7	-	-	-	-
3		Дархан сумын ХХС	1	50,847.3	-	-	-	-	1	50,847.3	-	-	-	-
4		Аймгийн ИТХ	1	607,125.0	-	-	1	607,125.0	-	-	-	-	-	-
5		Аймгийн ЗДТГ	3	47,863.4	1	2,343.4	1	32,500.0	1	13,020.0	-	-	-	-
6		Ахмадын хөгжлийн төв	2	5,143.7	1	220.1	-	-	1	4,923.6	-	-	-	-
7		Санхүүгийн хяналт, дотоод аудит	1	350.6	1	350.6	-	-	-	-	-	-	-	-
8		Худалдан авах ажиллагааны газар	1	7,130.6	-	-	-	-	1	7,130.6	-	-	-	-
9		Орхон сумын ХХС	2	66,289.6	-	-	2	66,289.6	-	-	-	-	-	-
10		Орхон сумын ИТХ	3	44,738.1	-	-	2	42,413.6	1	2,324.5	-	-	-	-
11		Орхон сумын ЗДТГ	1	6,732.0	-	-	-	-	1	6,732.0	-	-	-	-
12		Хонгор сумын ОНХС	1	1,354,546.1	-	-	-	-	1	1,354,546.1	-	-	-	-
13		Хонгор сумын ИТХ	2	133,210.0	-	-	1	125,000.0	1	8,210.0	-	-	-	-
14		Хонгор сумын ЗДТГ	2	3,774.8	1	774.8	-	-	1	3,000.0	-	-	-	-
15		Шарын гол сумын ЗДТГ	1	3,474.7	1	3,474.7	-	-	-	-	-	-	-	-
16		Шарын гол сумын ИТХ	1	34,560.0	-	-	1	34,560.0	-	-	-	-	-	-
		Дүн	26	2,805,642.4	5	7,163.6	9	1,342,888.2	12	1,455,590.6	-	-	-	-
1	ТС	Найрамдал төсөл	1	3,867.4	1	3,867.4	-	-	-	-	-	-	-	-
		Дүн	1	3,867.4	1	3,867.4	-	-	-	-	-	-	-	-
1	ТТЗ	Орхон сумын ТТЗ	2	42,000.0	-	-	1	42,000.0	1	-	-	-	-	-
2		Дархан сумын ТТЗ	1	435,000.0	-	-	1	435,000.0	-	-	-	-	-	-
3		Хонгор сумын ТТЗ	1	124,998.0	-	-	1	124,998.0	-	-	-	-	-	-
4		Шарын гол сумын ТТЗ	1	34,560.0	-	-	1	34,560.0	-	-	-	-	-	-
		Дүн	5	636,558.0	-	-	4	636,558.0	1	-	-	-	-	-
1		Амин холбоо ӨЭМТ	1	2,187.0	-	-	-	-	1	2,187.0	-	-	-	-

2	Госхот ӨЭМТ	1	3,005.6	-	-	-	-	1	3,005.6	-	-	-	-
3	Түвшин холбоо ӨЭМТ	3	77,457.1	-	-	2	2,514.0	1	74,943.1	-	-	-	-
4	Гэрэлтэй ӨЭМТ	1	3,870.9	-	-	1	3,870.9	-	-	-	-	-	-
5	МЭДС ТОБ ӨЭМТ	1	4,521.6	-	-	1	4,521.6	-	-	-	-	-	-
6	Ахмадын хороо	1	184.0	-	-	-	-	1	184.0	-	-	-	-
7	Дархан Ус суваг ОНӨХК	4	93,712.8	1	320.0	-	-	3	93,392.8	-	-	-	-
8	Орхон Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	5	25,899.0	2	903.2	1	8,907.1	2	16,088.7	-	-	-	-
9	Дархан хотын соёл амралтын хүрээлэн	2	173,873.7	-	-	1	118,445.5	1	55,428.2	-	-	-	-
10	Эрчим хүчний зохицуулах зөвлөл	1	537.8	1	537.8	-	-	-	-	-	-	-	-
11	Дархан хотын хог тээвэр	1	4,500.0	-	-	-	-	1	4,500.0	-	-	-	-
12	ХАА-н техник үйлчилгээний дундын төв	2	51,490.2	-	-	-	-	2	51,490.2	-	-	-	-
13	ДХББЗГазар ОНӨААТҮГ	2	20,875.5	-	-	1	20,875.5	1	-	-	-	-	-
14	Хонгор хот тохижилт ОНӨААТҮГ	2	4,204.0	-	-	-	-	2	4,204.0	-	-	-	-
15	Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ	1	2,875.0	-	-	-	-	1	2,875.0	-	-	-	-
16	Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ	2	2,500.0	-	-	-	-	2	2,500.0	-	-	-	-
17	Дархан юнайтед арена ОНӨААТҮГ	8	273,285.6	2	2,460.9	2	18,712.4	4	252,112.3	-	-	-	-
18	Тулга сувилал ОНӨААТҮГ	1	3,239.7	-	-	-	-	1	3,239.7	-	-	-	-
	Дүн	39	748,219.5	6	4,221.9	9	177,847.0	24	566,150.6	-	-	-	-
1	Аймгийн нэгтгэсэн тайлан	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
2	Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-
	Бүгд дүн	74	4,194,287.3	12	15,252.9	22	2,157,293.2	40	2,021,741.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>									
1	Хонгор сумын ЗДТГ	1	191,738.5	-	-	1	191,738.5	-	-
2	Орхон сумын ЗДТГ	1	23,141.5	-	-	1	23,141.5	-	-
3	Аймгийн ЗДТГ	1	219,574.5	-	-	1	219,574.5	-	-
4	Аймгийн ИТХ	1	1,894,136.9	-	-	1	1,894,136.9	-	-
5	Санхүүгийн хяналт, дотоод аудит	1	5,000.0	-	-	-	-	1	5,000.0
6	Шарын гол сумын ОНХС	1	1,150,910.4	-	-	-	-	1	1,150,910.4
7	Орхон сумын ОНХС	1	95,862.2	-	-	-	-	1	95,862.2
8	Дархан сумын ЗДТГ	1	5,000.0	-	-	-	-	1	5,000.0
9	Шарын гол сумын ЗДТГ	1	133,249.1	-	-	1	133,249.1	-	-
10	Ахмадын хороо	1	166,137.5	-	-	-	-	1	166,137.5
11	Дархан Ус суваг ОНӨХК	1	34,232.9	-	-	-	-	1	34,232.9
12	Эмт наран ОНӨААТҮГ	1	2,459.1	-	-	-	-	1	2,459.1
13	Дархан юнайтед арена ОНӨААТҮГ	1	911,427.6	-	-	-	-	1	911,427.6
14	Хонгор сумын ТЕЗ	1	-	-	-	-	-	1	-
Дүн		14	4,832,870.2	-	-	5	2,461,840.5	9	2,371,029.7
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>									
1	Орхон Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	1	161,234.1	-	-	1	161,234.1	-	-
Дүн		1	161,234.1	-	-	1	161,234.1	0	-
Нийт дүн		15	4,994,104.3	-	-	6	2,623,074.6	9	2,371,029.7